



## **Шинжээчийн үнэлгээний тайлан**

Байгууллагын нэр: МУИС, Шинжлэх ухааны сургууль

Хөтөлбөрийн нэр: “Эдийн засаг” бакалавр

Индекс: D031101

Шинжээчийн баг:

Ахлагч: Г.Баттүвшин

Гишүүд: Д. Далхжав

Ч. Наранчимэг

2023 оны 5 дугаар сарын 23

## Агуулга

### Товчилсон үгийн тайлбар

#### I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

#### II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

#### III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

#### IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

#### V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

#### VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

#### VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

## Товчилсон үгийн тайлбар

### Монгол үгс

БЦ	Багц цаг
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
БУС	Байгалийн ухааны салбар
БШУС	Боловсрол, шинжлэх ухаанын сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗХНГ	Захиргаа, хүний нөөцийн газар
КОНА	Номын сангийн автоматжуулсан программ
НУС	Нийгмийн ухааны салбар
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
МУИС	Монгол Улсын Их Сургууль
ХЧБХ	Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс
ӨҮТ	Өөрийн үнэлгээний тайлан
ХУС	Хүмүүнлэгийн ухааны салбар
ХШУИС	Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль
ШУС	Шинжлэх ухааны сургууль
ЭЗС	Эдийн засгийн сургууль
ЭЗТ	Эдийн засгийн тэнхим

### Гадаад үгс

CDIO	Conceive Design Implement Operate
JCR	Импакт фактор бүхий олон улсын мэргэжлийн сэтгүүл
PDS	Бүтээлийн хулгайгаас урьдчилан сэргийлэх, бүтээлийн хулгайг илрүүлэх
SiSi	МУИС-ийн СиСи сургалтын мэдээллийн систем

**I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Монгол Улсын их сургууль/ National University of Mongolia	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Эдийн засаг/ Economics	
<b>Индекс</b>	D 031101	
<b>Шинжээчид</b>	<p>Ахлагч:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Г.Баттүвшин доктор (Ph.D), Профессор. ШУТИС- ийн БАТС-ийн Захирал</li> </ul> <p>Гишүүд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Д.Далхжав доктор (Ph.D), Профессор. ХААИС-ийн профессор</li> <li>- Ч.Наранчимэг доктор (Ph.D), Профессор. СЭЗИС- ийн Суурь шинжлэх ухааны тэнхим</li> </ul>	
<b>БМИҮЗ-ийн ажлын албаны мэргэжилтэн</b>	Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч Д.Ганцэцэг	
<b>Төлөвлөгөө</b>	2023.05.12	Мэргэжилтэн шинжээчдэд ӨҮТ-г хүлээлгэн өгөх
	2023.05. 17	Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд өгөх
	2023.05.19	Сургуулийн бэлэн байдлыг нягтлах
	2023.05.22-23	Шинжээчид сургууль дээр ажиллах
	2023.06.05	Шинжээчийн баг зохицуулагчид шинжээчийн тайланг илгээх
		Магадлан итгэмжлэлд орж буй сургуульд шинжээчийн тайланг илгээх
		Сургууль шинжээчийн тайлантай танилцаж хариу өгч, шинжээчийн тайлан эцсийн байдлаар бэлэн болох
	Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр гарах	
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Шалгуур, шаардлага шинэчлэн батлах тухай” тогтоолын Гуравдугаар хавсралтаар батлагдсан шалгуур шаардлагын дагуу ажиллав.	

**МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн  
“Эдийн засаг” бакалаврын хөтөлбөрийн товч танилцуулга**

- Зорилго:
  - Хөтөлбөрийн хүрэх үр дүн PLOs (Program Learning Outcomes)
  - Хөтөлбөрийн зорилтууд PEO (Program Educational Objectives)
  - Хөтөлбөрийн төгсөгчийн загвар
  - Сургалтын төлөвлөгөөний бүтэц
  - Багшлах бүрэлдэхүүний нөөц, чадамж
  - Суралцагчдын тоо
  - Төгсөгчдийн тоо гэх мэт хөтөлбөртэй холбоотой мэдээлэл оруулах
-

## ШАЛГУУР 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

*Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.*

### **1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага**

Хөтөлбөр нь үндэсний болон олон ул боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Эдийн засгийн хөтөлбөр нь 1993 оноос “Эдийн засгийн онол” нэртэйгээр (Европын Холбооны Тасис хөтөлбөрийн хүрээнд ЭЗС-ийн хөтөлбөрүүдийг сайжруулах, багш нарын чадавхыг нэмэгдүүлэх 3 жилийн томоохон төслийн хүрээнд Англи Улсын Манчестерийн Их Сургуулийн Эдийн засгийн тэнхимийн шууд оролцоотой) хэрэгжиж эхэлсэн байна.

Тухайн үед эдийн засагч мэргэжлээр төгсөгчидийг бэлтгэдэг их дээд сургууль цөөн байсан нь төгсөгчдийн эрэлтийг нэмэгдүүлж улмаар хөтөлбөрийн хөгжил, хэрэгжилтэнд эерэг нөлөө үзүүлсэн байна.

Тухайн хөтөлбөрөөр төгсөгчдийн хувьд:

1. Төрийн байгууллага, үүнд Монголбанк, Сангийн Яам, Эдийн засаг, хөгжлийн яам, салбарын яамдууд зэрэг;
2. Их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний хүрээлэн, судалгаа шинжилгээний олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагууд;
3. Хувийн хэвшил тухайлбал, арилжааны банк болон бусад бизнесийн байгууллагууд;

Хөтөлбөрийн хувьд олон улсын тэргүүлэх их сургуулиудын хөиөлбөрүүдтэй (Дюкийн их сургууль, Австралийн Үндэсний их сургуулиудтай) харьцуулж ижил мэргэжлийн хөтөлбөрүүдтэй дүйцэхүйц түвшинд байна гэж үзжээ.

Харьцуулалтаас харахад манай тэнхимийн хөтөлбөрийн мэргэжлийн суурийн хичээлүүд нь бусад дэлхийн сургуулиудтай үндсэндээ таарч байна. Сонгон судлах хичээлийн хувьд манай хөтөлбөр нийт 42 багц цагийн 14 хичээлийг мэргэжлийн тэнхимээс судлах шаардлага тавьж байгаа бол харьцуулж буй хоёр сургуулийн хувьд мэргэжлийн сонгон суралцах хичээлүүд цөөн байна гэж үзжээ.

Мөн эдийн засгийн тэнхимээс санал болгож буй мэргэжлийн сонгоны нийт 32 хичээл нь дээрх олон улсын тэргүүлэх түвшний их сургуулиудын хөтөлбөрийн агуулгатай дүйцэхүйц байна гэж өөрийн үнэлгээний тайландаа тусгажээ.

Оролцогч талуудын болон тэнхимийн профессор багш нарын саналаар олон жил ороогүй буюу өөр хичээлтэй агуулга давхцсан зэрэг хичээлүүдийг хасах, нэмэх зэргээр хөтөлбөрийн өөрчлөлтийг тогтмол хийж явдаг төдийгүй ирэх хичээлийн жилээс Эдийн засгийн арт хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна<sup>1</sup>.

<sup>1</sup> Урьдчилсан тайлангийн 14-16 тал.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Тэнхимийн хөтөлбөрийн хорооны тэмдэглэл дугаар 20/60
- ШУС- ийн хөтөлбөрийн хорооны хурлын шийдвэр 2017/10/20
- Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурлын шийдвэр 2018-05-10
- Хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл 2021-11-12
- Ажил олгогчтой хийсэн фокус бүлгийн ярилцлагын судалгааны тэмдэглэл 2022-07-01
- МУИС- ийн Эдийн засаг хөтөлбөрийн тухай ажил олгогч ба төгсөгчдөөс авсан судалгааны үр дүнгийн тайлан. Б.Отгонтөгс нар. 2022.06.24
- Эдийн засаг хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг баталгаажуулан МУИС-ийн вэбсайт, СиСи сургалтын удирдлагын системд цаг тухай бүрт оруулдаг

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Хөтөлбөр нь манай боловсролын салбарын тэргүүний хөтөлбөрүүдийн нэг, онолын болон тооцоолол, шинжилгэний ур чадваруудыг маш сайн олгодог
- Хөтөлбөрийн уламжлал, боловсон хүчний ур чадвар, хөтөлбөрийн мэдлэгийн хуримтлал маш сайн.
- Хөтөлбөрийн сайжруулалт шинэчлэл гэхээсээ илүүтэйгээр уламжлалт хандлагаа илүү баримталдаг
- Олон улсын тэргүүлэх их сургуулиудтай дүйцэхүйц.
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд суурилан хөтөлбөртөө англи хэлний ур чадвар, дата анализ, data science хичээлүүдийг тусган өгч байна.

**Анхаарах асуудал:**/Сул тал/

- Хатуу ур чадвар сайн олгож буй боловч зөөлөн ур чадвар олгох хичээл, сургалтын арга хэрэгслүүд хангалтгүй
- Хөтөлбөрийн шинэчлэл, хөтөлбөрийн сайжруулалтанд сонирхогч талуудын оролцоог хангадаг гэсэн боловч оюутан, төгсөгч, ажил олгогч нартай хийсэн ярилцлагаар батлагдсангүй.
- Зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахын тулд хөтөлбөрөөр төгсөгчдийн хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор олон сонгодог хичээл байгаа гэж буй боловч оюутнуудын ярилцлагаас анги бүрдээгүй, багш байхгүй гэсэн шалтгаанаар сонгодог хичээлүүд явагддаггүй
- Хөтөлбөрийн дэд бүтцийн төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай

**Үнэлгээ:** /Хэсэгчлэн хангасан,/

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хийх явцад сонирхогч талуудын оролцоог хангах;
- Сургалтыг оюутан төвтэй болгоход анхаарч ажиллах

**Шаардлага:** /Хэсэгчлэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

- Сонгодог хичээлүүдийн хувьд цөөн оюутан сонгосон ч цөөн оюутны ч эрх ашгийг хангах тал дээр анхаарал хандуулах, байгууллагын соёлыг бүрдүүлэхэд анхаарах

## **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

*“Эдийн засгийн мэргэжлийн хөтөлбөрийн зорилго эдийн засгийн шинжлэх ухааны үндсэн ойлголт, онолыг судалж эзэмисэн; нийгэм, эдийн засгийн зүй тогтол, үйл хөдлөл, хамаарлыг ойлгосон; нийгэм, эдийн засгийн мэдээлэл, тоон өгөгдлийг шинжлэх мэдлэг, практик ур чадвартай; эзэмисэн мэдлэг, чадвараараа хамт олон, нийгэмд үр дүнтэй хүргэн манлайлж, нийгмийн тогтвортой хөгжилд тасралтгүй хувь нэмэр оруулахуйц цогц чадамж бүхий эдийн засагчийг бакалаврын түвшинд бэлдэхэд оршино.”* гэж тодорхойлсон.

Хөтөлбөрийн дээр дурдсан зорилгын хүрээнд дараах 3 зорилтыг дэвшүүлсэн.

1. Зах зээлийн агентуудын үйл хөдлөл, оновчтой сонголтын талаарх эдийн засгийн онол, үндэсний болон дэлхийн эдийн засаг бүхэлдээ хэрхэн ажилладаг талаар гүнзгий мэдлэгт тулгуурлан, нийгэм, эдийн засгийн асуудлыг математик, статистик, эконометрикийн аргыг ашиглан шинжлэх чадвар олгох;
2. Эдийн засгийн аливаа санаа, нотолгоо, дүгнэлт, тайлбар, аргументыг бусдад үр дүнтэй ойлгуулах, нийгэм дэх эдийн засаг болон төрийн бодлогын асуудлаар өөрийн байр суурийг тодорхойлох, илэрхийлэх чадвар эзэмшүүлэх;
3. Нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, иргэний нийгмийн ёс зүйтэй иргэнийг төлөвшүүлэх.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Зорилго зорилтууд сайтан дээр байхгүй бна.
- 2014 онд батлагдсан Эдийн засаг хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг баталгаажуулан МУИС-ийн вэбсайт, СиСи сургалтын удирдлагын системд цаг тухай бүрт оруулдаг.



<https://sisi.num.edu.mn/hutulbur/Scripts/ViewerJS/#/.../hutulbur/Curriculum/Download/2895> о

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Нийгмийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах манлайлагчдийг бэлтгэх хэмээн өргөн хүрээтэйгээр хөтөлбөрийн зорилгоо тодорхойлсон байна.
- Сургах сурах үйл явцыг дэлхийн тэргүүлэх түвшинд хүргэх
- Өргөн сонголтыг бий болгох
- Нийгэмд мэдлэгээр манлайлж нийгмийн хөгжлийн түүчээ болно.

**Анхаарах асуудал:**/Сул тал/

- Урьдчилсан үнэлгээний тайлан болон СиСи дээр байгаа хөтөлбөрийн зорилго зорилтын мэдээллүүд зөрсөн
- 2014 онд батлагдсан Эдийн засаг хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг оюутанд ойлгомжтой байхаар үзүүлэх
- Суралцахад сургах (сургах тухай л яригдаж байна.)
- Тогтвортой хөгжлийн бодлого их сургуульд гүйцэтгэх үүрэг, их сургуулийн тогтвортой хөгжлийн бодлогод нөлөөлөх нөлөө зэрэг нь тодорхойгүй.

**Үнэлгээ:** /Бүрэн хангасан /

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Суралцахад сургах тал дээр хөтөлбөрийн хэрэгжилтийн дизайн тал дээр анхаарал хандуулах

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

МУИС нь сургалтын хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг боловсруулахдаа дараах хууль, журам, заавар, зөвлөмжид нийцүүлсэн. Үүнд:

1. Монгол Улсын Боловсролын тухай хууль
2. Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль
3. БШУС-ын 2022.05.09-ны А/160 тоот тушаалаар батлагдсан “Мэргэжлийн чиглэл (хөтөлбөрийн нэр), индекс шинэчлэн батлах тухай”, БСШУСС-ын 2017.06.29-ний

А/52 тоот тушаалаар батлагдсан “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, 2020.07.01-ний А/308 тоот тушаалаар батлагдсан “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”

4. БШУС-ын 2014.04.28-ны А/174 тоот тушаалаар батлагдсан Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага
5. МУИС-ийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл, 960001
6. МУИС-ийн Сургалтын хөтөлбөрийн журам

Эдийн засаг мэргэжлийн багц цаг нь (хүснэгт 1.2) нийт 120 байхаар төлөвлөж МУИС-ийн хөтөлбөр боловсруулах шаардлагын хүрээнд ерөнхий суурь 36 багц, мэргэжлийн суурь 9 багц, мэргэжлийн 60 багц, сонголтын 15 багц байхаар тогтсон байна. Мэргэжлийн хичээлүүд нь оюутанд мэргэжлийн анхдагч ур чадварыг эзэмшүүлэхээс гадна ёс зүй, эрх зүн суурь ойлголтуудыг өгөх зорилготой заавал болон сонгох хичээлүүдээс бүрддэг байна. Ер нь хөтөлбөртөө багаар ажиллах ур чадвар, ёс зүй олгоход чиглэгдсэнээс гадна хос мэрэгжил эзэмших боломж олгохоос гадна ахисан түвшний хөтөлбөрийг мөн сонгож үзэх боломжийг бүрдүүлсэн онцлогтой байна.

Хаталёарийн суралцахуйн үр дүнг дараах байдлаар томъёолсон байна. Үүнд.

1. Эдийн засгийн ухааны мэдлэг ба ойлголт
2. Задлан шинжлэхүй ба шүүмжлэлт сэтгэлгээ
3. Харилцаа ба манлайлал
4. Нийгмийн тогтвортой хөгжилд оруулах хувь нэмэр

Мөн хөтөлбөртөө SWOT шинжилгээг хийж үүндээ өөрийн хөтөлбөрийг дэлхийн шилдэг их сургуулиудын бакалаврын хөтөлбөрийн жишигт хүрсэн гэж өөрсдийн үнэлгээг өгчээ.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

Хөтөлбөрийг боловсруулахдаа мэргэжлийн ур чадвараас гадна багаар ажиллах, мэргэжлийн ёс зүйтэй байх зэрэг ойлголтуудыг тусгаж өгч байгаа нь хөтөлбөрийн төлөвлөлтийн сайн тал болох нь ойлгомжтой. Мөн задлан шинжлэх, шүүмжлэлтэй хандлагыг бий болгох зэрэг ур чадавгаар дамжуулан тогтвортой хөгжлийн хандлагыг оюутанд олгох зорилгоор хөтөлбөрөө боловсруулж буй нь XXI зууны мэрэгжилтэн зайлшгүй байх ур чадваруудыг эзэмшүүлж буй хөтөлбөр болжээ.

**Анхаарах асуудал:**/Сул тал/

- Хэдийгээр хөтөлбөрийг боловсруулах, шинэчлэл хийхдээ ажил олгогч, төгсөгч, оюутны оролцоог хангадаг гэж тэнхимийн багш хэлж мөн өөрийн үнэлгээний тайландаа тусгасан боловч дээрх төлөөллүүдтэй ярилцах явцад энэ асуудал нь батлагдсангүй.
- Мөн төгсөгчидтэй ярилцах явцад зах зээл дээр яг эдийн засагч гэж мэрэгжил байдаггүй болон энэ тэнхимийн төгсөгчидийн хөдөлмөрийн зах зээл явцуу, мэрэгжил нь хөрвөх чадвар муутай гэсэн саналууд гарч байлаа.

- Ажил олгогчдын зүгээс (Монгол Банкны төлөөлөл, Сангийн яам бусад) хөтөлбөрийг төлөвлөхдөө дараах асуудлуудыг анхаарах санал дэвшүүлж байв. Үүнд:
- Хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт хэрэгцээг сайн судалж байх
- Хөтөлбөртөө шинээр бий болж буй технологийн шийдлүүдийг тусгах
- Хөтөлбөрийн хөгжүүлэлтийг байнга хийх
- Зөөлөн ур чадвар олгох тал дээр ажиллах
- Хэлний ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах

**Үнэлгээ:** /Бүрэн хангасан/

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг нээлттэй байлгах, мөн орлцогч талуудын санал, зөвлөмжийг төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгахад голлон анхаарах.

**Шаардлага:** /Хэсэгчлэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

## ШАЛГУУР 1.

**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ:** /Бүрэн хангасан/

### Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

#### 2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

Дээд боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд 2014 онд “Эдийн засаг” хөтөлбөрийг шинээр баталсан.

Түүнээс хойш хөтөлбөрт удаа дараа, тухалбал 2015, 2018, 2019, 2020, 2021 онуудад өөрчлөлтийг оруулж олон улсын жишигт нийцүүлэх ажлыг хийсээр иржээ. Гэхдээ МУИС-ийн бүтцийн өөрчлөлтөөс улбаатайгаар хөтөлбөрт их өөрчлөлтүүд орсон байна. Жишээ нь эдийн засгийн онолын тэнхим нь Статистикийн болон Хүн ам зүйн тэнхимтэй

нийлэх үед тухайн тэнхимүүдийн багш нарын заадаг хичээл нэмэгдэж заавал үзэх хичээлийн тоо хэт нэмэгдэж байсан, агуулга давхардсан хичээлийн тоо нэмэгдсэн зэрэг. Эдийн засгийн хөтөлбөрийн чанарыг сайжруулахын тулд 2017-2018 оны хичээлийн жилд хөтөлбөрийн ерөнхий суурийн хичээлүүдээс MATH100, ECON101, ECON102 индекс тэй хичээлүүдийг тус тус заавал амжилттай судалсан байх шаардлага нэмж оруулсан. Мөн онд Эконометрикийн үндэс болон Дунд түвшний эконометрикс хичээлүүдийн индекс STAT202-оос ECON202, STAT204-оос ECON204 болсон. ECON323 индекс тэй хичээл болох Ногоон эдийн засгийн бодлого хичээлийг шинээр нэмж, STAT308 Статистик хэрэглээний программ, STAT310 Эконометрикийн хэрэглээний программ, STAT414 Хэрэглээний статистик хичээлүүдийг тус бүр хөтөлбөрөөс хассан.

2018-2019 оны хөтөлбөрийн шинэчлэлээр нийт 3 өөрчлөлт орсон ба эхний өөрчлөлт нь мэргэжлийн сонгон судлах багцад байсан дараах 10 хичээлийг хичээлийн хөтөлбөрөөс хасчээ. Мөн 2020-2021 оны хичээлийн жилд заавал судлах хичээлүүдээс 3 хичээлийг сонгон луу шилжүүлж, мэргэжлийн сонгон суралцах хичээлээс 7 хичээлийг хассан байна.

Эдийн засгийн бакалаврын хөтөлбөр нь либерал арт боловсролын хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн хөтөлбөр байна.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

Хөтөлбөрийн шинэчлэлийг хий явцдаа суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, орчин үеийн эрэлт шаардлагад нийцсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, хичээлүүд нь харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг сургалтыг (i) төлөвлөх, (ii) хэрэгжүүлэх, (iii) үнэлэх, (iv) сайжруулах гэсэн 4 үе шаттай хэрэгжүүлж байна.

Мөн сүүлийн жил хийгдсэн хөтөлбөрийн шинэчлэлээр хичээл тус бүр дээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлж төлөвлөж байгаа нь сайшаалтай байна.

Хичээлийн улирлын эцэст МУИС-ийн Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтсээс оюунуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч хэвшсэн байна.

**Анхаарах асуудал:**/Сул тал/

- Сургуулийн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан хөтөлбөрт тэнхим бүрийн багш нарыг хичээлтэй байлгах зорилгоор олон тооны хичээлийн нэмэлт буюу хасалт хийж байгаа нь суралцагчдад хүндрэл учруулж байна.
- Хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлгээ төдийлөн хийдэггүй учраас сайжруулалт нь хэрхэн явагдаж байгаа нь ойлгомжгүй.
- СиСи системд орж үзэхэд хөтөлбөрийн өөрчлөлт нь хэрхэн явагдсан болон сүүлийн хувилбарт ямар өөрчлөлт орсон нь ойлгомжгүй байлаа.
- Улирлын эцэст авч буй сэтгэл ханамжийн судалгааг шинэчлэлд тусгадаг байх.

**Үнэлгээ:** /Бүрэн хангасан/

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Сургуулийн бүтцийн өөрчлөлт нь хөтөлбөрийн сургалтын агуулгад сөргөөр нөлөөлж байгаа тул сургуулийн зүгээс хөтөлбөрийн бие даасан академик нөхцөлийг хангаж өгөх
- Тэнхимийн зүгээс хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг хийж хэвших, зөвхөн багшийн үнэлгээнд бус олон талт үнэлгээний систем боловсруулах,

## **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

МУИС-ийн Сургалтын хөтөлбөрийн тухай журам болон МУИС-ийн Сургалтын үйл ажиллагааны тухай журамд лекц, семинар, лаборатори болон дадлагын тодорхойлолтыг зааж өгсөн байдаг ба үүнд тухайн хичээлийн арга зүйн ерөнхий хэлбэрийг тусгасан байдаг. Үүнд тулгуурлан “МУИС-ийн Хичээлийн хөтөлбөр боловсруулах заавар”-ын дагуу хичээлийн хамтлаг хичээл тус бүрээр тохирох арга зүйг хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хичээлийн суралцахуйн үр дүн болон хичээлийн агуулгад нийцүүлэн боловсруулж, хичээлийн хөтөлбөрт тусган тэнхимийн хөтөлбөрийн хороогоор баталгаажуулдаг.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд уламжлалт болон орчин үеийн идэвхтэй сургалтын аргуудыг хослуулан ашигладаг ба МУИС-д профессор багш ажиллуулах журмын хавсралтад зааснаар МУИС-ийн багш нь суралцагчийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн, асуудал шийдвэрлэх, тоглоомын арга, тодорхой тохиолдлын судалгаа (кейс) г.м сургалтын шинэлэг аргыг нэвтрүүлэх зорилттой ажилладаг. Сургалтад ашиглаж буй арга зүй нь суралцагчийн шүүмжлэлт сэтгэхүй хөгжүүлэх, мэдлэг хуримтлуулах, бүтээлч санаачлага бий болгох, өөрийн үзэл бодлыг үндэслэлтэй илэрхийлэх, онолын мэдлэгийг бодит амьдралын үйл ажиллагаанд хэрэглэх үр чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн байдаг.

Хөтөлбөрийн шинэчлэл заах арга зүйн хүрээнд Колумбын их сургуулийн докторантаас цахим сургалт авсан байна.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

Нээлттэй хичээлийн систем болох ОСW системийг ашиглан багш нар хичээлийн лекцийн материал, видео бичлэг, лаборатори, семинарын даалгаврыг системд оруулж эхэлсэн.

Мөн онлайн сургалтын контент боловсруулах зориулалт бүхий Дижитал профессорын студийг байгуулж ажиллаж байна. Зарим нэгэн хичээлүүдийг цахим хэлбэрээр явуулж байна.

Багш нар нь заах арга зүйн сургалтанд хамрагдаж байна.

**Анхаарах асуудал:**/Сул тал/

- Багш нараа заах эрга зүйн модуль сургалтанд хамруулж буй боловч энэ нь эхлэл төдий байна.
- Эдийн засгийн тэнхимийн хувьд заах арга зүйн болон ур чадварын тухай харилцан бие биетэйгээ хуваалцах, хичээлийн арга зүй, үнэлгээний аргачлалыг хамтран ярилцаж сайжруулах, шинэ багш туршлагатай багш нарын хичээлд суух, туршлагатай багш нар зөвлөн туслах зэргээр багшлахуйн ур чадвараа сайжруулах асуудал дэр хамтын ажиллагаа сул байгааг дурдах хэрэгтэй. (43 х.)
- Оюутнуудтай хийсэн ярилцлагаас багш ярьдаг оюутнуудад сонсдог уламжлалт арга хэвээр оршисоор байна.

**Үнэлгээ:** /Хэсэгчлэн хангасан/

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Оюутнууд зарим багш нараас тодруулах зүйл асуухад багш үл тоодог гэсэн энэ асуудлыг онцгой анхаарч багш нартаа сургах арга зүй талаас нь сургалт явуулах шаардлагатай байна.

**Шаардлага:** /Хэсэгчлэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

- Залуу багш нарын багшлахуйн ур чадвараа сайжруулах тал дээр сургуулийн зүгээс онцгой анхаарч дэмжих тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

### 2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- МУИС-ийн Сургалтын үйл ажиллагааны тухай журам нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 10 сарын 06-ны өдрийн “Үлгэрчилсэн журам батлах тухай” А/348 тушаалын заалтуудтай үндсэндээ нийцэж байгаа.

Уг журамд зааснаар тухайн хичээлээр суралцагчийн улирлын туршид эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээг гаргахдаа дараах аргачлалыг баримтална. Үүнд:

- $O_1$  – Оюутны хичээлийн идэвх оролцоо буюу хичээлд оролцсон бүтээлч ирц, семинар, дадлага, хичээлд бэлтгэгдсэн байдал зэрэгт багшийн өгсөн үнэлгээ;

- O<sub>2</sub> – Суралцагчийн явцын үнэлгээ буюу улирлын явцад хийсэн илтгэл, реферат, тайлан, хяналтын ажил, сэдвийн үнэлгээний дундаж болон явцын шалгалтын нийлбэр;
- O<sub>3</sub>– Улирлын шалгалтын үнэлгээ байна.
- “Суралцагчийн мэдлэг, чадварыг оноогоор үнэлэх аргачлал”-ын дагуу 100 оноогоор үнэлэх бөгөөд үнэлгээний нэмэлт тэмдэглэгээ ашигладаг нь үнэлгээний ил тод байдлыг оновчтой харуулж чадаж байна гэж үзлээ.
- Хичээлийн тодорхойлолтод ерөнхий болон сэдэв бүрээр эзэмших мэдлэг чадвар дадал, улирлын явцын болон эцсийн шалгалтын оноог хэрхэн үнэлэхээ нарийвчлан заасан байдаг.
- Эдийн засгийн тэнхимээс заадаг хичээлүүдийг сонгосон оюутнуудын сурлагын дундаж онооны үзүүлэлтүүдийн намар болон хаврын улирлын сүүлийн 9 жилийн үзүүлэлтүүдийг харьцуулсан үзүүлсэн байна.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн SWOT шинжилгээ хийсэн байна.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Сургалтын үйл ажиллагааны тухай журамд заасны дагуу үнэлгээ нь шинжлэх ухааны үндэстэй, бодитой, шударга ил тод байх зарчмыг багш баримталдаг. 4
- Багш нь ирц идэвхийн оноо, явцын үнэлгээ болон шалгалтын дүнг тогтмол сургалтын мэдээллийн системд оруулдаг ба ингэснээр суралцагч өөрийн ирц, явцын оноо үнэлгээтэй танилцах боломжийг бий болгодог.
- Хичээл бүрийн хувьд оюутны эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг эзэмшсэн эсэхийг үнэлэн тогтоох үзүүлэлт ба шалгалт авах хэлбэр, даалгаврын тоо, түүний агуулга, бүтэц, хариулт бэлтгэх хугацаа зэргийг багш сургах арга зүйн үүднээс нарийн төлөвлөн боловсруулсан байна.

**Анхаарах асуудал:**/Сул тал/

- Хичээлийн явцын болон шалгалтын эзэтшвэлзохих мэдлэг, ур чадварыг хэмжих шалгуур болох тестийн сан, сорил, шалгалтын сангуудад хийсэн шинжилгээ дутагдалтай байлаа.
- Мөн оюутнуудын зүгээс хичээлийн явцыг болон шалгалтын үнэлгээ хэрхэн тооцогдож гарсан нь зарим нэг багшийн хувьд хаалттай байдаг гэж ярьж байлаа.
- Оюутнуудын сурлагын дундаж онооны үзүүлэлтээс хичээл сонгосон оюутнууд ерөнхий суурь хичээл дээрээ харьцангуй өндөр оноотой мэрийлттэй суралцдаг боловч мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлүүд дээрээ харьцангуй сулардаг болох нь харагдаж байлаа. Зарим жилүүдэд мэргэжлийн хичээлийн дундаж оноо 0 буюу F үнэлгээтэй байхад 2021-2022 оны хичээлийн жилийн мэргэжлийн суурь хичээлийн хаврын дундаж оноо 1,5 буюу C хүрэхгүй (65-69 оноотой)байгаа нь хачирхалтай.

**Үнэлгээ:** /Хэсэгчлэн хангасан/

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Үнэлгээний аргачлалын тасралтгүй сайжруулж байгаа гэж тайланд өгүүлэх боловч ерөнхий суурь хичээлүүдийг сайн эзэмшиж байсан оюутнууд яагаад мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлүүдэд нийлэнхдээ мууддаг болох нь ойлгомжгүй байна.

**Шаардлага:** /Хэсэгчлэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

- Оюутны үнэлгээний аргачлал болон бидит үнэлгээ тавьж буй байдалд хөндлөнгийн үнэлгээг хийлгэх механизмыг бүрдүүлэх,
- Оюутны үнэлгээнд хэт субъектив хандлага давамгайлж байна гэж үзэж буй тул сургууль, тэнхимийн зүгээс бодлогоор тухайн асуудалд анхаарал хандуулах.

## **ШАЛГУУР 2.**

**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ:** /Хэсэгчлэн хангасан/

### **Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Эдийн засаг хөтөлбөрт суралцагч оюутнуудад сургалт, судалгаа явуулах 5 анги танхим, лаборатори хичээлийн V байранд байх бөгөөд лаборатори, хичээллэх анги танхим нь стандартад нийцсэн.
- Сургалтын орчны судалгаа
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага

**Онцлог зүйл:**

- Эдийн засгийн хөтөлбөрийн багш оюутнууд МУИС-ийн хичээлийн бүх байранд хичээллэх боломжтой.
- Сургалтын орчны судалгаа тогтмол хийгддэг.
- Номын санд суух бололцоо сайн, сэтгэл ханамжтай байх нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн.
- Хичээлийн анги танхим хангалттай. Анги бүр проектор болон суурин компьютертой.

**Анхаарах асуудал:**



- Суралцагчтай хийсэн ярилцлагын үеэр хичээлийн байр дамжиж хичээл орох тохиолдолд завсарлагааны 10 минутад дараагийн цагийн хичээлдээ ирж амжихгүй хоцрох тохиолдол гардаг, үүнээс үүдэн хичээл орж буй багш хоцорсон гээд оруулахгүй бол хичээлдээ суух боломжгүй нөхцөл үүсдэг гэсэн коммент гарсаныг цаашид анхаарах
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан зам болон тусгай хэрэгцээт орчин нөхцөл бүрдээгүй.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:**

- Хангамж үйлчилгээний албандаа санал хүсэлт гаргаж хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан зам болон тусгай хэрэгцээт орчин нөхцөлийг бүрдүүлэх

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургалтын үйл явцаа Teams болон СиСи удирдлагын мэдээллийн системээр дэмжиж өгдөг. СиСи системээр дамжин сургалтын орчны үзүүлэлтээ нэгтгэж гаргадаг.
- Суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааны сургалтын орчны талаарх үзүүлэлт
- Сургуулын хэрэглэгдэхүүний судалгаа
- Суралцагч ба төгсөгчид, багш нартай хийсэн уулзалт, ярилцлага

**Онцлог зүйл:**

- Компьютерийн лабораторид ашиглагддаг програмууд нь албан ёсны лицензтэй.
- Сургалтын хэрэглэгдэхүүний судалгаа тогтмол хийгддэг.
- Багш нар микрофон, чихэвч, камераар бүрэн хангагдсан. Шаардлагатай багш нарт таблет, зөөврийн компьютер авч өгсөн.
- Утасгүй сүлжээний ашиглалт сайн, чанар хэвийн, 252Мбит/сек хурдтай.

**Анхаарах асуудал:**

- Байхгүй.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Номын сангийн нөөцийн судалгаа, ашиглалтын тайлан
- Хичээлийн V байрны Оюутны бие даах төвийн номын фондын мэдээ
- Тэнхимийн багш нарын хэвлүүлсэн сургалтад ашигладаг ном сурах бичгийн судалгаа
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт ярилцлага
- Багш нартай хийсэн бүлгийн болон ганцаарчилсан уулзалт ярилцлага

#### **Онцлог зүйл:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч Эдийн засгийн тэнхимээс “Эдийн засаг: онол, практик” сэтгүүлийг тогтмол эрхлэн гаргадаг. Энэхүү сэтгүүл нь олон улсын редакцийн зөвлөлтэй, багш судлаачид бүтээлээ хэвлүүлэхийг зоридог нэр хүндтэй сэтгүүл юм.
- Багш ажилтны хөгжлийг дэмжих сантай. Энэ сангаас шаардлагатай тохиолдолд багш нарт санхүүжилтийн дэмжлэг үзүүлдэг.
- Тэнхимийн багш нар Cengage-ийн ном сурах бичиг дагалдах бүрдэл материалыг сургалтандаа ашигладаг.

#### **Анхаарах асуудал:**

- Монгол хэл дээрх сурах бичгийн хүрэлцээ хангамж муу

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Зөвлөмж:**

- Сургалтад тогтмол ашиглагддаг монгол хэл дээрх ном сурах бичиг, гарын авлагын тоо ширхэгийг олшруулах, нэмж худалдан авах зардалыг төсөвлөх
- Сургалтад ашиглах монгол сурах бичгийн нэр төрөл, тоог нэмэгдүүлэх. Үүний тулд багш нарыг сурах бичиг, гарын авлага боловсруулах, бичиж хэвлүүлэх зэрэгт санхүүгийн болон Б цагийн дорвитой дэмжлэг үзүүлэх механизмийг бүрдүүлэхэд чиглэсэн дүрэм журмын өөрчлөлтийн саналыг удирдлагуудад хүргүүлэх

### **ШАЛГУУР 3.**

**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ:** Бүрэн хангасан

#### **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

##### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- “Хөтөлбөрийн хорооны журам”-ыг МУИС-ийн захирлын 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/347 тоот тушаалаар баталгаажуулж, 2017 оноос 2021-2022 оны хичээлийн жилийг дуустал хугацаанд амжилттай хэрэгжүүлсэн.
- МУИС-ийн Захирлын 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/256 тоот тушаалаар “МУИС-ийн Сургалтын хөтөлбөрийн журам”, “МУИС-ийн Сургалтын үйл ажиллагааны журам” гэсэн хоёр хэсэг журмыг шинэчлэн боловсруулж батлан энэ хичээлийн жилээс мөрдөгдөж байгаа.
- Анхан шатны \тэнхмийн\ хороодын бүрэлдэхүүнд ажил олгогчдын болон төгсөгчдийн төлөөлөл орсон байх ба бүх шатны хөтөлбөрийн хороог 3 жил тутам шинэчилж байхаар журамд тусгасан
- Эдийн засгийн тэнхмийн хөтөлбөрийн хороо өнгөрсөн хугацаанд 4 удаа шинэчлэгдсэн.
- Тэнхим сургалтын хөтөлбөрт оруулах өөрчлөлтийн саналаа тэнхимийн хурлаар, эсвэл өөрийн харьяа профессорын багаар хэлэлцүүлж, ТХХ-нд танилцуулаад дэмжигдвэл БСХХ-нд уламжилж, ХЕХ-гоор шийдүүлдэг журамтай.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч “Эдийн засгийн тэнхим” суралцагчид болон төгсөгчид, мөн ажил олгогчдоос сэтгэл ханамжийн судалгаа авах замаар хөтөлбөрийн шинэчлэл хэр үр дүн өгч байгааг үнэлэн дүгнэх оролдлогыг өнгөрсөн хичээлийн жилүүдэд хийж ирсэн. Өнгөрсөн жилийн төгсөгчид ба ажил олгогчдын төлөөллийг хамруулан хийсэн судалгаанаас үзвэл төгсөгчдийн мэдлэг, ур чадварын түвшин дунджаас үл ялиг дээгүүр байгаа. \Зураг 4.2. Мэдлэг, ур чадварын үнэлгээний талаарх төгсөгчдийн судалгаа\
- Өнөөдөр, тус ТХХ-ны ахлагчаар тэнхимийн эрхлэгч доктор Ч.Нарантуяа, нарийн бичгийн даргаар доктор Б.Энхмаа, гишүүнээр доктор Н.Ууганбаатар, доктор Б.Бат, доктор Б.Түвшинтөгс, ажил олгогчийг төлөөлж Монголбанкны хэлстйн захирал Н.Ургамалсувд, SIJB Capital группын дэд захирал Р.Мөнхтөр, төгсөгчийг төлөөлж Ч.Алтан-Өлзий нар ажиллаж байна.

##### **Онцлог зүйл:**

- МУИС эдийн засагч мэргэжлээр бакалаврын түвшинд мэргэшүүлэх хөтөлбөрөөр 1947 оноос өнөөг хүртэл тасралтгүй сургалт явуулж, байгаа.

- Эдийн засгийн тэнхим сургалтын үйл ажиллагаандаа МУИС-ийн алсын хараа, эрхэм зорилгыг эрхэмлэн 2016-2024 онд хэрэгжүүлэх МУИС-ийн Стратегийн төлөвлөгөөг мөрдлөг болгон ажиллаж байгаа.
- 2014 онд хийсэн хөтөлбөрийн удирдлага, хяналтын тогтолцоог шинэчлэх ажлын хүрээнд хөтөлбөрийн удирдлага, хяналтыг эрхэлсэн, сонирхогч талуудын төлөөллөөс бүрдсэн хөтөлбөрийн хороог гурван шатанд байгуулан ажиллуулсан. \тэнхмийн хөтөлбөрийн хороо, бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн хороо, МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороо\
- Өнгөрсөн хугацаанд \2016-2022\ Эдийн засгийн бакалаврын хөтөлбөрийн талаар ШУС-ийн Хөтөлбөрийн хороогоор 12 удаа асуудал оруулан хэлэлцүүлснээс 10 асуудал дэмжигдсэн бол 2014-2018 оны хооронд Эдийн засгийн тэнхимээс ХЕХ-гоор 3 удаа асуудал оруулж, 2 нь дэмжигдэн хэрэгжсэн.

#### **Анхаарах асуудал:**

- Ажил олгогчдоос гарч байгаа дараах асуудлуудыг хөтөлбөрийн шинэчлэлд анхаарч үзэх. Үүнд:
  - o Мэргэжлийн англи хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэх
  - o Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тодорхой түвший мэдлэг олгох хичээлүүд оруулах
  - o Судалгааны арга зүй эзэмшүүлэх сургалтын цагийг нэмэгдүүлэх
  - o Зөөлөн ур чадвар эзэмшүүлэх чиглэлд түлхүү анхаарах
  - o IT чиглэлийн сургалтыг нэмэгдүүлэх
  - o Төрийн институцүүдээс сангийн бодлогоор судалгаа шинжилгээ хийх чадвар эзэмшүүлэх

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрт оруулах өөрчлөлтийн талаар хөтөлбөрт оролцогч талуудаас гарсан санал тодорхой бус зөвхөн тэнхмийн саналууд байгаад анхаарах

**Шаардлага:** /Хэсэгчлэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Эдийн засгийн тэнхим Монгол банк, Сангийн яам, ҮСХ, БОАЖЯ, Азийн Хөгжлийн банк, Дэлхийн банк, Эдийн засгийн хүрээлэн, ERI, NRCC, Монголын Эдийн Засгийн Шинжилгээ Судалгааны Төв зэрэг байгууллагуудтай хамтран судалгаа, шинжилгээний ажлуудыг гүйцэтгэсээр ирсэн. 2017-2022 оны хичээлийн жилүүдэд эдгээр байгууллагуудтай хамтран 20 орчим төсөлд багш нарын 90% орчим нь хамрагдан оролцсон.
- Эдийн засгийн тэнхимийн профессор, доктор Б. Эрдэнэбат Япон улсын Нийгата мужид байрлах Зүүн Хойд Азийн Судалгааны Хүрээлэн, Киото Их Сургууль, Нийгата Их Сургууль, Хоккайдо Их Сургууль болон Франц улсын Парисын Их Сургуульд уригдан ажилласан.
- 2018-2019 оны хичээлийн жилээс тэнхимийн профессор, доктор Б.Отгонтөгс АНУ-ын Америкийн Их Сургуультай хамтран Жендерийн эдийн засаг хичээл, судлагдахууныг МУИС-д нутагшуулахаар ажиллаж байгаа.
- 2017 онд профессор Х.Цэвэлмаа, 2019 онд дэд профессор Ч.Нарантуяа нар Швед Улсын Лулео Технологийн дээд сургуульд багш солилцооны хөтөлбөрөөр явж нэг сарын турш хичээл заасан.
- Мөн тэнхимийн зүгээс нийгэм, олон нийтэд чиглэсэн ажлуудын нэг бол бизнесийн байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа. Эдийн Засгийн хүрээлэн болон профессор Ч.Хашчулуунаар удирдуулсан тэнхимийн багш нарын баг Оюу толгой компанийн захиалгаар “Оюу Толгойн Нийгэм Эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ”-г 2018, 2021 онуудад хийж гүйцэтгэсэн.
- Тэнхимийн багш нарын хамтарч ажилладаг гадаадын судлаач, эрдэмтэн нарыг тэнхимийн семинарт илтгэл тавиулах, зөвлөгөө авах замаар хамтарч ажилладаг. 2019-2020 онд Австралийн Үндэсний Их сургуулийн профессор Hal Hill, Америкийн Их Сургуулийн профессор Mieke Meurs нар хамтран ажиллаж байгаа.
- Эдийн засгийн хөтөлбөрийн оюутнууд хамрагдах боломжтой МУИС-д хэрэгжүүлдэг тэтгэлэг, урамшуулал, хөнгөлөлтүүд:
  - МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг
  - МУИС-ийн шинэ элсэгчийн тэтгэлэг
  - Оюутан солилцооны тэтгэлэгт хөтөлбөрүүд
  - Элсэгчдийг дэмжих тэтгэлэг:
    1. Олон улсын олимпиадад оролцож 1-3-р байр эзэлсэн элсэгчийн эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 100 хувь хөнгөлнө.
    2. Улсын олимпиадад 1-р байрт шалгарсан бол эхний хичээлийн жилийн төлбөрийг 100 хувь, 2-р байрт шалгарсан бол 75 хувь, 3-р байрт шалгарсан бол 50 хувь хөнгөлнө.
    3. Суурь шалгалтад тооцуулсан байгалийн ухааны ЭЕШ нь 750-аас дээш оноотой ШУС-ийн БУС, ХШУИС-ийн эхний 50 элсэгч /сургууль тус бүрд 25/, мөн математик, физик, хими, биологи, техник

технологи, мэдээлэл зүйн улсын олимпиадад 1-3-р байранд шалгарч дээрх сургуулиудад элссэн бол 50 хувь хөнгөлнө.

- Тэтгэлэгийн талаарх мэдээллийг тэнхимийн цахим хуудас дээр байршуулсан байна. <https://dep.num.edu.mn/econ/>

-

#### **Онцлог зүйл:**

- Япон Улсын Кобэ Их Сургуулийн оюутан солилцооны хөтөлбөрийн хүрээнд Эдийн засаг, түүх, Япон судлалын хөтөлбөрийн бакалавр, магистрын оюутнууд 1 жилийн хугацаатай дээрх сургуульд тэтгэлэгтэйгээр суралцаж боломжийг эдийн засаг хөтөлбөр олгож байгаа.
- Ахисан түвшний оюутны сургалт болон судалгааг дэмжих зорилгоор Монголбанкттай 2020 онд “Тинк банк” хөтөлбөрийн гэрээ байгуулан хамтарч ажиллаж байгаа. Өнөөгийн байдлаар хөтөлбөрт нийт 7 оюутан хамрагдаж, 157.5 сая төгрөгийн санхүүжилтийг МУИС-д оруулсан байна.
- Тэнхимийн зүгээс SICA LLC судалгааны хүрээлэнтэй хамтран оюутны дадлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээг 2021 онд ШУС-ийн НУС-ын түвшинд байгуулсан.

#### **Анхаарах асуудал:**

- Оюутны саналыг үндэслэн тодорхой нэг салбараар дагнан мэргэшүүлэх, дадлагын хугацаа, багц цагийг нэмэгдүүлж, ажил олгогчтой гэрээ байгуулан суралцуулах
- Оюутан солилцооны хөтөлбөр гаргаж, хэрэгжилтэнд анхаарах

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Зөвлөмж:**

- МУИС-ийн 2024 он хүртэл хөгжүүлэх стратеги, ерөнхий зорилго “Алсын хараа”-д тусгагдсан чөлөөт мэдлэг буюу “Либерал арт” гэсэн чиглэлээ эргэн харж, оюутанд хүндэтгэлтэй хандах
- Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан 111 дүгээр хуудсанд Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусалсан байдалын талаар тодорхой илтгэж, холбогдох цахим холбоосуудыг оруулсан байгаа боловч оюутнуудтай хийсэн уулзалтаар бүрэн нотлогдохгүй байна. Иймд тэнхимийн оюутны дунд нийгэм, эдийн засагт тулгамдсан сэдвүүдээр эрдэм шинжилгээ судалгааны ажил хийлгэх, ЭШБ хурал зохион байгуулах, шалгаруулалт хийж, урамшуулах

### 4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### Илрэл нотолгоо:

- 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн МУИС-ийн хэмжээнд төсвийн төлөвлөлт, орлого хуваарилалт, бүтээгдэхүүний өртөг тооцооллын шинэ журамд шилжин ажиллаж байгаа. Төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлуудыг тэнхимийн жил бүрийн ажлын төлөвлөгөөнд нарийвчлан тусгаж хэрэгжүүлж ирсэн.
- Эдийн засгийн тэнхим нь Шинжлэх Ухааны Сургуульд (ШУС) харьяалагддаг бөгөөд санхүүжилтийг захиран зарцуулах эрх нь ШУС-ийн захиралд байдаг.
- Тэнхим төсвөө төлөвлөхдөө тухайн хичээлийн жилд оюутан болон багшийн үйл ажиллагаанд шаардлагатай зардлуудыг өмнөх хичээлийн жилийн зарцуулалтын дундаж, тухайн жилийн зорилготой уялдуулан боловсруулж ШУС-д хүргүүлдэг.
- ШУС-ийн Нийгмийн ухааны салбарын 2016-2021 оны зардлын тооцоог задлан шинжлэхэд нийгмийн ухааны салбарын төсвийн нийт зардлын 85-87 хувь нь цалин, 13-15 хувь нь бараа үйлчилгээний зардал байна. Зураг 4.3.1-ээс харвал ШУС-ийн Нийгмийн ухааны салбарын 2021 оны нийт зардалыг 2016 онтой харьцуулахад 48 хувиар өссөн байна. Зардлын өсөлтийг зардлын төрлөөр нь задалж үзвэл Урсгал засварын зардлын өсөлт 85,4 хувь, Эрдэм шинжилгээний зардал 13,8 хувь, Бичиг хэрэг, аж ахуйн зардал 11,6 хувийн өсөлттэй байна.
- Оюутны нэг багц цагийн сургалтын төлбөр 2016 онд 82.1 байсан бол 2021 онд 100.7 мянган төгрөг болж өссөн
- Сүүлийн 5 жилд тус тэнхимийн багш оюутнууд 22 нэр төрлийн 1781,3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл хөтөлбөрт оролцсон байна. \ӨҮТ 92-93 дугаар хуудас Хүснэгт 4.10\

#### Онцлог зүйл:

- ШУС-ийн Нийгмийн ухааны салбар 2021 онд багш оюутнуудын сурч, ажиллах нөхцөл, сургалтын орчныг сайжруулах зорилгоор хичээлийн байр, анги танхимд урсгал засвар хийсэн. Мөн эрдэм шинжилгээний зардал 13,8 хувь, оюутан, үйлчилгээний зардал 42 хувь, хичээлийн практикийн зардал 29 хувийн өсөлттэй байгаа нь сургалтын төлбөрийн орлогыг хөтөлбөрийн багш, суралцагчдын хөгжилд зарцуулдаг болохыг харуулж байна.
- 2016-2021 онд ШУС-ийн Нийгмийн ухааны салбарын орлого 3,9 тэр бум төгрөгөөс 6,5 тэр бум төгрөг болж 65 хувиар өссөн. Орлого нэмэгдснээр төсвийн зарцуулалт нэмэгдэх боломжийг бүрдүүлсэн байна.
- 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдсан МУИС-ийн оюутнуудын “Асуудал, шийдэл-2018” форумын үеэр МУИС-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, МУИС-ийн Захиргаа, МУИС-ийн Оюутны холбоо, Оюутан конгресс тус форумын үеэр гурван талт гэрээнд гарын үсэг зурж, МУИС-ийн

Төлөөлөн удирдах зөвлөл бүрэн эрхийнхээ хугацаанд оюутны сургалтын төлбөрийг нэмэгдүүлэхгүй байх үүрэг хүлээсэн. Оюутны нэг багц цагийн сургалтын төлбөр 2021 онд 2016 оныхоос 22.7 хувиар өссөн бөгөөд сүүлийн жилүүдэд сургалтын төлбөр өсөөгүй, тогтвортой байгаа

- Тэнхим өөрийн мэдлийн бага хэмжээний төсөвтэй тухайлбал 2020 онд 17,9 сая төгрөг, 2021 онд 17,6 сая төгрөг, 2022 онд 14,9 сая төгрөг тус тус тус хуваарилагдсан байна. Тэнхим төсвөө зарцуулах тусгай журамтай энэхүү журмаар “ чиглэлээр төсвөө зарцуулдаг. Үүнд:
  - Сургалтын чадавхи
  - Судалгааны чадавхи нэмэгдүүлэх
  - Хувь хүний чадавхийг нэмэгдүүлэх гэсэн чиглэлтэй зарцуулагддаг

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын төлбөрөөс гадна эрдэм шинжилгээ судалгаа болон бусад эх үүсвэрээс оруулж байгаа санхүүжилтын эх үүсвэр тодорхойгүй
- Тус хөтөлбөрөөр элсэгч нэг оюутны орлого, зарлагын тооцоо тодорхойгүй

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн элсэлтийн үйл ажиллагааг таниулах үед бүрэлдэхүүн сургуулиуд дээр хэрэгжүүлж буй мэргэжлийн хөтөлбөрүүдийн талаар товч мэдээллийг Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчид, эцэг эхчүүдэд хэвлэмэл материал, видео танилцуулга байдлаар Сургалтын нэгдсэн албанаас бэлтгэж БСШУСЯ, Аймаг орон нутгийн удирдлагууд, ТББ зэргээр дамжуулан хүргэдэг. Энэ үйл ажиллагаа нь 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн жил бүрийн хавар тогтмол явагдсаар ирсэн.
- Мөн мэргэжлийн хөтөлбөр сонгох үйл ажиллагааны өмнө оюутнуудад хөтөлбөрөө сурталчлах, таниулах өдөрлөгийг бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхимүүд, холбогдох алба нэгжийн зүгээс зохион байгуулдаг. Энэ үйл ажиллагаанд гадаад, дотоодын их дээд сургууль төгсөж салбартаа амжилт гаргаж яваа мэргэжилтнүүд өөрсдийн туршлагаа оюутан залуустай хуваалцаж “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ”, “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ”, “Ирээдүйн чиг хандлагыг ойлгох” гэх мэт цуврал уулзалт ярилцлагыг зохион байгуулж зөвлөгөө өгч ажилладаг.



- Хөтөлбөр сурталчлах өдөрлөг нь тухайн хичээлийн жилийн намар болон хаврын улиралд тус бүр нэг удаа зохион байгуулагддаг.
- Маркетингийн идэвхжүүлэлтийн нэг томоохон арга хэрэгсэл нь тэнхим бүрийн хөтөлбөр сурталчлах өдөрлөг байдаг. Үүнд хуваарийн дагуу жилд 2 удаа намрын улирал (XI сард), хаврын улирал (IV сард) бакалаврын хөтөлбөр сурталчлах өдөрлөгт оролцдог. Тус үйл ажиллагаа нь тус бүр нэг өдөр үргэлжилдэг.
- Өдөрлөгөөр дараах ажлууд хийгддэг. Үүнд: Хөтөлбөрийн товч танилцуулга хийх, тараах, Хөтөлбөрийн талаар лавлагаа, мэдээлэл өгөх, Эдийн засагчийн ажлын байрны талаар мэдээлэл өгөх,
- Хөтөлбөр сурталчлах үүрэг бүхий нэг том үйл ажиллагаа нь “Эдийн засгийн цагаан толгойг хэн сайн мэдэх вэ” нэртэй бизнес, эдийн засгийн чиглэлийн мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудын нэгдүгээр түвшний оюутнуудын дунд зохиогддог олимпиад байсан.

#### **Онцлог зүйл:**

- Элсэлт буурах болсон шалтгааныг судлан дараах 6 хүчин зүйлтэй холбож үзсэн:
  - Хөтөлбөрт элсэх тусгай шаардлага тавьсан
  - 2. Хөтөлбөр сонгох эрх бүхий оюутны олонлог (pool) явцуурсан
  - 3. Одоо суралцаж буй оюутны сэтгэл ханамж боломжийн
  - 4. Мэргэжил тандалт болон сонголт, түүний зөрүү (сонирхол ерөнхийдөө буурсан)
  - 5. Математикийн суурийн нөлөө (НУС дээр бага)
  - 6. Хөтөлбөрт шилжихэд тавьж буй шаардлага (босго)

**Анхаарах асуудал:** /Сул тал/

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөр тогтвортой байдлаа хангахуйц идэвхижүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөө гаргах
- Элсэлт нэмэгдүүлэх арга хэмжээг тодорхой болгох

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-д хэрэгжиж буй бакалаврын болон ахисан түвшний хөтөлбөрүүдийн танилцуулга, суралцахуйн зорилгод үр дүн, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц, суралцах ачаалал, багц цаг, суралцахуйн үнэлгээний

аргачлал зэрэг хөтөлбөртэй холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэйгээр дараах албан ёсны эх сурвалжуудаар түгээдэг. Үүнд:

- <https://www.num.edu.mn/> - МУИС-ийн цахим хуудас
- <https://elselt.num.edu.mn/> - МУИС-ийн Элсэлтийн цахим хуудас
- <https://burtgel.num.edu.mn/negdsen> - МУИС-ийн Бүртгэлийн нэгдсэн систем
- <https://graduate.num.edu.mn/> - Ахисан түвшний сургуулийн цахим хуудас
- <https://sas.num.edu.mn/> - Шинжлэх Ухааны Сургуулийн цахим хуудас
- <http://dep.num.edu.mn/econ/> - Эдийн засгийн тэнхимийн цахим хуудас
- <https://www.facebook.com/economicsatnum/> - Эдийн засгийн тэнхимийн facebook хуудас
- @econ\_num – Эдийн засгийн тэнхимийн twitter хуудас
- <https://www.youtube.com/watch?v=iQm7-wdBCFA> – Элсэгчдэд зориулсан хөтөлбөрийн танилцуулга
- <https://youtu.be/SGDX6Mj4JR4> – Эдийн засаг хөтөлбөрийн танилцуулга
- <http://econjournal.mn/> - Эдийн засаг: онол, практик сэтгүүл Мөн тэнхимийн цахим хуудсанд тэнхимд харьяалалтай хөтөлбөрийн мэдээлэл дэлгэрэнгүй байршдаг.
- Хэвлэмэл байдлаар МУИС-ийн элсэлт, бүртгэлийн хэлтэс жил бүр элсэлтийн болон суралцагчийн гарын авлагыг эрхлэн гаргадаг.
- Тэнхимийн зүгээс оюутнуудад зориулсан хөтөлбөрийн танилцуулга, видео хийж түгээдэг.

Эдгээр эх сурвалжуудад тухайн хөтөлбөрт өөрчлөлт орсон тухай бүрт мэдээллийг шинэчлэн байршуулдаг. МУИС-ийн багш, суралцагчдад дээрх эх сурвалжуудаас гадна МУИС-ийн сургалтын удирдлага, мэдээллийн СиСи систем <https://sisi.num.edu.mn> – ээр дэлгэрэнгүй мэдээллийг хүргэж, тогтмол шинэчилдэг байна.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

#### **Анхаарах асуудал:**

- Элсэгчид төгсөгчидтэй хийсэн уулзалтын мэдээлэл, хөтөлбөрийн мэргэжлийн тодорхойлолтоос үзэхэд “Эдийн засагч” хөтөлбөрөөр суралцагч төгсч гараад ямар ажлын байранд очих нь тодорхойгүй, ямар нэгэн ажлын байранд очиж тодорхой хугацаанд ажилласны дараа мэргэших шаардлага үүсч байна

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **ШАЛГУУР 4.**

**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ:** Бүрэн хангасан

**Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС нь Монгол Улсын "Дээд боловсролын тухай хууль", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 03 дугаар сарын 18-ны А/79 тоот тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам", Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/194 тоот "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тушаал, Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчдад суралцагчийн тэтгэлэг олгох журам" бусад холбогдох эрх зүйн актыг үндэслэнэ.
- МУИС-иас жил бүр бакалаврын өдрийн хөтөлбөрт оюутан элсүүлэх журмыг боловсруулан баталж, бакалаврын өдрийн хөтөлбөрийн элсэлтийг зохион байгуулдаг.
- Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд МУИС 2015 оноос эхлэн бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэгчдийг тодорхой мэргэжлийн хөтөлбөрт бус харин бүрэлдэхүүн сургуульд бүртгүүлэн элсүүлж, ерөнхий суурийн тодорхой хичээл судалсны дараа мэргэжлээ сонгох боломжоор хангах бодлогыг хэрэгжүүлж байсан.
- 2023-2024 оны хичээлийн жилээс эхлэн Хөтөлбөрүүдэд шууд нэр заан элсэлт авах бодлого баримтлаж эхэлсэн.
- Хөтөлбөрөөр элсэгч нь ЭЕШ-ийг математик суурьтай өгсөн байх бөгөөд 640 өөс дээш оноотой байхыг шаарддаг. Одоогоор элсэгчийн дундаж оноо 645,4- 646,4 байна.

#### **Онцлог зүйл:**

- Ерөнхий боловсролын сургууль (ЕБС) төгсөгч нь МУИС -ийн Бүртгэлийн систем ([www.burtgel.num.edu.mn](http://www.burtgel.num.edu.mn))-д цахим хэлбэрээр бүртгүүлэх боломжтой.
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар баталсан улсын олимпиадад байр эзэлсэн болон оролцсон, босго онооны болзол хангасан ЕБС төгсөгч нь урьдчилан МУИС-д элсэх боломжтой
- Элссэн оюутан үндсэн мэргэжлээс гадна МУИС-иас санал болгох "Хос" болон "Хавсарга" мэргэжлээс сонгон судлах;
- ШУС болон ХШУИС-д элсэгчид гүнзгийрүүлсэн сургалтат хөтөлбөр (honours program)-т хамрагдах;
- МУИС-ийн ерөнхий суурийн зарим хичээлийг англи хэл дээр сонгон судлах

- Кембрижийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй ерөнхий боловсролын сургуулиудыг төгсч МУИС-д элссэн оюутнуудын А болон AS түвшинд судалсан хичээлийг МУИС-ийн Ерөнхий суурийн хичээлтэй багц цаг дүйцүүлэн тооцдог.

**Анхаарах асуудал:**/Сул тал/

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

## **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн зүгээс суралцагчдыг хөгжүүлэх, дэмжих, зөвлөх, чиглүүлэх чиглэлээр олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулдаг. Энэ үйл ажиллагааг Оюутан, төгсөгчийн хэлтэс хариуцдаг бөгөөд тухайн хичээлийн жилийн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө гаргаж, хуваарийн дагуу үйл ажиллагааг зохион явуулдаг.  
Үүнд:
  - оюутны тэтгэлэг,
  - санхүүгийн дэмжлэг,
  - боловсролын зээлийн үйлчилгээ,
  - оюутан солилцоо,
  - гадаад оюутныг дэмжих үйлчилгээ,
  - хөдөлмөр эрхлэлтийг дэмжих,
  - хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад үзүүлэх үйлчилгээ,
  - хууль эрх зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ,
  - соёл спортын үйлчилгээ,
  - эрүүл мэндийн зөвлөх үйлчилгээ,
  - судалгаа болон санаалагыг дэмжих үйлчилгээ,
  - дотуур байр, орон сууцны үйлчилгээ,
  - оюутны нийгэмд хандсан үйлчилгээ,
  - цахим үйлчилгээ болон хамтын үйл ажиллагаа гэсэн зөвлөн туслах үйлчилгээнүүдийг жагсаасан байна.
- Элсэгчид зөвлөх багш ажиллуулдаг. Зөвлөх багш нар дараах асуудлаар зөвлөгөө өгдөг:
  - Сургалтын хөтөлбөр болон сургалтын төлөвлөгөө
  - Хөтөлбөр төгсөхөд тавих шаардлага

- Хичээлийн уялдаа, залгамж холбоо (хичээлийн “мод”)
  - Хичээлүүдийн талаар ерөнхий ойлголт, тодорхойлолт
  - Хувийн суралцах төлөвлөгөө зохиоход анхаарах зүйлс
  - Дадлагад гарахад тавих шаардлага
  - Хос (double major) болон хавсарга (minor) хөтөлбөрөөр суралцах боломж
  - Тэтгэлэг болон интерншипийн талаарх мэдээлэл
  - Ирээдүйн карьер, түүнд бэлдэх, ажлын байрны шаардлага, сонгох хичээлүүд
  - Асуудал үүсэхэд шийдвэрлэх албаны мэргэжилтэнтэй холбож өгөх
  - МУИС-ийн дүрэм, журмыг танилцуулах Хөтөлбөрийн оюутнуудад тэнхимийн зүгээс мэдээллийг өөрийн цахим хуудсаараа дамжуулан хүргэдэг.
- Зөвлөх багш нар болон тэнхимийн туслах ажилтан хөтөлбөрийн оюутнуудтай олон сувгаар харилцдаг.
    - Нийт оюутнууд - тэнхимийн вэб -<https://dep.num.edu.mn/econ/?cat=3>
    - Тэнхимийн fb хуудас - <https://www.facebook.com/economicsatnum>
    - 3-р түвшин <https://www.facebook.com/groups/276662537610376>
    - 4-р түвшин <https://www.facebook.com/groups/405562399962068>
  - Элсэлт бүртгэлийн хэлтэс жил бүр шинэ элсэгчдэд зориулж суралцагчдад шаардлагатай бүхий л мэдээллийг багтаасан гарын авлага хэвлэн гаргадаг.
  - МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд хамтран МУИС-ийн төгсөгчдийг ажлын байртай болгох, ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагуудад МУИС-ийн төгсөгчдөөс хүний нөөцөө бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, оюутнуудын байнгын болон зуны амралтаар хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “CAREER & JOB FAIR” өдөрлөгийг төлөвлөгөөний дагуу жил бүр зохион байгуулдаг уламжлалтай. Монголын томоохон аж ахуй нэгж болох Таван богд групп, Витафит групп “Гоё” тарагны үйлдвэртэй танилцах аялал, МУИС, Бизнетворк ХХК, хамтран “Орлоготой оюутан” хөтөлбөрийн хүрээнд “Түр ажлын байрны өдөрлөг” тус тус зохион байгуулдаг. Сургуулийн кампуст ажиллах оюутны тоог нэмэгдүүлэх зорилгоор шинэ номын сангийн байран дахь брэнд дэлгүүр, номын дэлгүүр, кофе шопт оюутнуудыг цалинтай ажиллуулж байна.

#### **Онцлог зүйл:**

- МУИС-д 2015 оноос оюутны үйлчилгээний хэлтэс байгуулагдсан
- 2023 оноос оюутны хөгжлийн асуудал эрхэлсэн захиралтай болсон

**Анхаарах асуудал:**/Сул тал/

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### **Зөвлөмж:**

- Сургалтын технологи хэрэгжилтийн явцад хяналт тавьж оюутны саналд хүндэтгэлтэй хандах
- Зөвлөх багш нарын зөвлөн туслах үйлчилгээнд хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс тавих хяналтыг сайжруулах

### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн хэмжээнд Оюутан, төгсөгчийн хэлтэс зохион байгуулан олон төрлийн клубууд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус хэлтэс нь хичээлийн жилийн улирал бүрийн эцэст оюутны клубуудээс тухайн улиралд зохион байгуулсан үйл ажиллагааны тайланг хүлээн авч, идэвхтэй ажиллаж байгаа клубуудыг шалгаруулан дараагийн улиралд үйл ажиллагаагаа явуулах өрөө тасалгаа, шаардлагатай үед боловсруулсан удирдамжид нь үндэслэн төсвөөр хангах зэргээр ажилладаг. МУИС-ийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг клубууд:
  - Залуучуудын улаан загалмай клуб
  - INTRO англи хэлний ярианы клуб
  - Undergraduate Women in Business Mongolia клуб
  - НАСКУМ клуб Мэдээлэл технологийн чиглэлийг барьж үйл ажиллагаа явуулдаг.
  - Илтгэл, парламентын мэтгэлцээний “Өөрчлөлт” клуб
  - Best” клуб илтгэх урлаг, парламентийн мэтгэлцээний чиглэлээр сургалт явуулдаг.
  - Монголын Соёлын Байгууллага” (МСО) клуб
  - “Лука” клуб Орос хэл болон Хүмүүнлэгийн гэсэн хоёр чиглэлтэй.
  - “Билим” клуб нь МУИС-ийн Казах оюутнуудын сайн дурын нэгдэл
  - “Залуу Социологич” клуб
  - БСОН Бизнесийн Сургуулийн Оюутны Нэгдэл Клуб
  - ХОС УЯНГА Монгол бичиг соёлын клуб
  - Экологи клуб
  - “Unity of Science” судалгаа, мэтгэлцээний клуб
  - “Номтой найзалъя” клуб Эдийн засгийн тэнхим дээр “Economist” клуб 2022-2023 оны хичээлийн жилээс үйл ажиллагаа явуулах хүсэлтээ ШУС-ийн захиргаанд албан ёсор гаргаад байна.
- Клубын ерөнхийлөгчөөр 2-р түвшний оюутан Т.Номинзул ажиллаж байна. Клубын гишүүнээр одоогоор 54 оюутан элсээд байгаа, мөн 2022-2023 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулсан гэсэн мэдээллийг өөрийн

үнэлгээний тайлангийн 113 дугаар хуудсанд илтгэсэн байна. Үүний нотолгоог оюутнуудаас асуухад дээрх олон клубуудыг сонсож байсан бид оролцдоггүй харин энэ хичээлийн жилээс бид нэг клуб байгуулж ажиллуулахаар болсон гэсэн мэдээллийг өгч байсан.

**Онцлог зүйл:**

- МУИС-ийн дэргэд оюутны үүсгэл санаачлагаар байгуулагдсан нийгэмд үйлчлэх өөрсдийгөө хөгжүүлэх олон клуб, олон нийтийн байгууллагууд ажилладаг Эдийн засаг хөтөлбөрөөр элсэн суралцагсад хамрагдах боломжтой.

/Давуу тал, сайн туршлага г.м/

**Анхаарах асуудал:**

- Эдийн засаг хөтөлбөрөөр суралцагсад дээрх олон нийтийн үйл ажиллагаанд хамрагдах оролцоо сул байгаа нь уулзалтын явцаас ажиглагдсан тул үүнийг идэвхижүүлэх ажлыг хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжээс анхаарч үзэх

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

**Шаардлага:** /Хэсэгчлэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

**5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Тусгай шаардлага хангасан тохиолдолд МУИС-ийн хөтөлбөр хооронд, мөн гадаад дотоодын их, дээд сургуулиас шилжин суралцах боломжтой. Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.
- МУИС-ийн захирлын 2019 оны 11-р сарын 14-ний өдрийн А/483 тоот тушаалаар “МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам” шинэчлэгдэн батлагдсан.
- Тус журамд дотоодын их, дээд сургуулиас шилжин суралцагсдад тавигдах шаардлага, гадаадын их, дээд сургуулиас шилжин суралцагсдад тавигдах шаардлага, МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжин суралцагсдад тавигдах шаардлага, шилжилтийн бүртгэл, шилжилтийн шалгалт, багц цаг дүйцүүлэн тооцох, шилжилттэй холбоотой зардал зэргийг нарийвчлан заасан. Шилжилт

хөдөлгөөнийг хичээлийн жилд 2 удаа зохион байгуулах бөгөөд шилжилтийн бүртгэлийг намрын улиралд 7-р сарын 01-ээс 8-р сарын 15, хаврын улиралд 12-р сарын 15-аас 01-р сарын 15-ыг дуустал <https://burtgel.num.edu.mn> бүртгэлийн нэгдсэн системээр бүртгэнэ.

- Шилжин суралцагч нь хүссэн хөтөлбөрийн дагуу шалгалт өгөх бөгөөд шалгалтад авбал зохих онооны 60-аас доошгүй хувийг авсан шилжин суралцагчдыг оноогоор нь жагсааж хяналтын тоонд багтаан элсүүлнэ.
- Эдийн засгийн хөтөлбөрт МУИС-ийн бусад бүрэлдэхүүн сургууль, салбар, тэнхимээс шилжиж ирэх хүсэлт гардаг. Шилжиж ирэх хүсэлт гаргах эрх дээр дурдсан МУИС-ийн нийтлэг журмаар зохицуулагддаг. Үүний дээр Эдийн засгийн хөтөлбөрийг сонгох тусгай шаардлага болох Математик, Микро болон Макро эдийн засгийн үндэс гэсэн 3 хичээлийг амжилттай судалсан байх шаардлагыг тавьдаг. Эдгээр шаардлагыг хангасан оюутнуудаас шилжилтийн шалгалтыг тэнхимээс томилсон комисс авах бөгөөд агуулгын хувьд Микро эдийн засгийн үндэс, Макро эдийн засгийн үндэс хичээлүүдийн сэдвүүдийг хамардаг.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

**Анхаарах асуудал:**/Сул тал/

**Үнэлгээ:** /Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

**Шаардлага:** /Хэсэгчлэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

### **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

**Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн захирлын захирлын 2022 оны 6-р сарын 27-ны өдрийн А/256 тоот тушаалаар батлагдсан Сургалтын үйл ажиллагааны журмын 4.6.51-т заасны дагуу амжилттай сурч, дээд боловсролын бакалаврын зэргийн болзол хангасан суралцагчийн төгсөлтийн салбарын комиссын шийдвэрийг үндэслэн МУИС-ийн захирлын тушаалаар төгссөн мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх төгсөлтийн баримт бичиг болох диплом, дипломын хавсралт, энгэрийн тэмдэг олгодог байна.
- Бакалаврын зэргийн диплом нь МУИС-ийн Удирдах зөвлөлийн дарга, МУИС-ийн захирал, төгсөлтийн ерөнхий комиссын дарга, бүрэлдэхүүн сургуулийн захирлын



гарын үсэг, МУИС-ийн тамга тэмдгээр баталгаажих ба дугаар, бүртгэлийн дугаартай байдаг.

- Дипломын хавсралтанд оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг илтгэх мэргэшүүлэх хичээлүүдийн оноог илтгэсэн байдаг.
- Төгсөлтийн салбар комисс сургуулийн архивт төгсөгчтэй холбоотой төгсөлтийн салбар комиссын хурлын шийдвэр, диплом олгосон бүртгэлийн хуулбар, хамгаалуулах зөвлөлийн хуралдааны протокол, тогтоол, удирдагчийн тодорхойлолт, суралцсан хугацааны тодорхойлолт, дипломын хуулбар, сурлагын дүнгийн эх хувь нэг, дэлгэрэнгүй анкет, суралцагчийн үнэмлэх болон тойрох хуудас зэрэг баримт бичгүүдийг бүрдүүлж өгдөг журамтай.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

**Анхаарах асуудал:**

- Төгсөгчдын уулзалтаас ажлын байрны нарийвчилсан тодорхойлолтгүй гардаг, ажлын байранд очиж тодорхой хугацааны дараа ажиллах мэдлэг, ур чадвараа олж авдаг гэх мэт санал гарсаныг анхаарч үзэх
- Ажил олгогчдоос гарсан саналд тус хөтөлбөрөөр төгсөгчдийг Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн чиглэлээр мэргэшүүлэх хичээлийг хөтөлбөрт оруулах гэсэн саналыг анхаарч үзэх

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

**ШАЛГУУР 5.**

**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ:** Бүрэн хангасан

**Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

**6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилгоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- МУИС-д профессор багш ажиллуулах журам

- МУИС-д зөвлөх, гэрээт ба зочин профессор, цагийн багш ажиллуулах журам
- Тэнхимийн багш нарын албан тушаалын зэрэглэлийн мэдээлэл
- Тэнхимийн багш нарын эрдмийн зэрэг цол, сургалт судалгааны чиглэл
- Багш оюутны тооны харьцаа
- Багш нартай хийсэн уулзалт, ярилцлага

#### **Онцлог зүйл:**

- Эдийн засгийн тэнхим нь хүний нөөцийн хувьд МУИС-даа тэргүүлэх түвшинд бэхэжсэн.
- Тэнхимийн багш нарын 79.2% доктор зэрэгтэй, ихэнх нь гадаадад хамгаалсан.
- Тэнхим нь хоёр туслах ажилтан, нэг лаборанттайгаас гадна сургалтын инженер багштай.

#### **Анхаарах асуудал:**

- Профессор зэрэглэлийн болон профессор цолтой багш нарын тоог нэмэгдүүлэх

#### **Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Зөвлөмж:**

- МУИС-ийн Профессор багшийн зэрэглэлд тавигдах тусгай шаардлагыг хангасан багш нарын орон тоог баталгаажуулж, албажуулах

## **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн Багшийн хөгжлийн хөтөлбөр (2019-2024) бодлогын баримт бичиг
- Багш ажилтныг дэмжих зардлын санхүүжилтийн тэнхимийн судалгаа
- Багш нартай хийсэн бүлгийн болон ганцаарчилсан уулзалт ярилцлага
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт ярилцлага

#### **Онцлог зүйл:**

- МУИС-ийн Багшийн хөгжил, цахим сургалтын төвөөс багшийн хөгжил рүү чиглэсэн төрөл бүрийн сургалт зохион байгуулдаг бөгөөд тэнхимийн багш нар хэрэгцээтэй сургалтууддаа хамрагддаг соёл бүрдсэн.
- Багшийн хөгжил, цахим сургалтын төвийн сургалтуудад тэнхимийн багш нараас сургагч багшаар оролцдог.
- Тэнхимийн судалгааны семинарыг хуваарийн дагуу тогтмол явуулж хэвшсэн.
- Зочин багшийн хөтөлбөр хэрэгжүүлдэг.

#### **Анхаарах асуудал:**

- Байхгүй.

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

### **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн 2016-2024 оны стратегийн төлөвлөгөө
- МУИС-ийн судалгааны санхүүжилтийн журам
- МУИС-ийн шагнал урамшууллын нийтлэг журам
- Тэнхимийн багш нарын МУИС-ийн судалгааны санхүүжилтэд хамрагдсан байдлын судалгаа
- Тэнхимийн багш нарын гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын тоо мэдээ
- Хэвлүүлсэн ЭШ-ний өгүүлэл, илтгэл буюу ЭШ-ний ажлын бүтэц /ӨҮТ, Зураг 6.1/
- Чансаатай сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлийн тоо мэдээ
- Шилдэг зохиогчийн шагнал авсан багш нарын судалгаа
- 2019-2022 онуудад гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний төсөлт ажлын жагсаалт
- Багш нартай хийсэн бүлгийн болон ганцаарчилсан уулзалт ярилцлага

#### **Онцлог зүйл:**

- Тайлант хугацаанд МУИС-аас санхүүжилттэй төсөлд хоёр судалгааны төсөл шалгарч, уг хоёр төслийг хэрэгжүүлсэн. Үүнд: “Хятадын өсөн нэмэгдэж буй нөлөө: Олон улсын өсөлтийн холбоост гарч буй өөрчлөлт” сэдэвт судалгааны төсөл, “Уул уурхайн салбарын хөгжил ба өрх гэрийн ядуурал, тэгш байдалд үзүүлж буй нөлөө” сэдэвт судалгааны төсөл
- МУИС-ийн санхүүжилттэй судалгааны бүх төрлийн тэтгэлэг, төслүүдэд тэнхимийн багш нар идэвхтэй хамрагддаг.
- 2019-2022 онуудад тэнхимийн багш нар 72 ЭШ-ний бүтээл өгүүлэл, 33 илтгэл тус тус хэвлүүлсэн. 42 ЭШ-ний төсөл гэрээт ажил хийж гүйцэтгэсэн.
- Web of Science –ийн сэтгүүлд сүүлийн 4 жилд 8 өгүүлэл хэвлүүлсэн.
- Мэргэжлийн түвшинд хянагддаг сэтгүүлд 34 өгүүлэл хэвлүүлсэн.

#### **Анхаарах асуудал:**

- Байхгүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

#### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Багшийн өөрийн үнэлгээний тайлан
- Багш нарын А, Б, В цагийн гүйцэтгэлийн тайлан мэдээ
- МУИС-д профессор, багш ажиллуулах журам
- Багш нартай хийсэн бүлгийн болон ганцаарчилсан уулзалт ярилцлага
- Багш нарыг аттестатчилалд хамруулах тухай тушаал, түүний үр дүн тайлан
- СиСи системээр авдаг суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаа, судалгааны үр дүн
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт ярилцлага

#### **Онцлог зүйл:**

- Багшийн ажлыг үнэлэх тогтолцоо бүрдсэн.
- Багшийн хөндлөнгийн үнэлгээ хийгддэг.
- Тайлант хугацаанд багшийн аттестатчилал хоёр удаа явагдсан байх бөгөөд нийт багш нарын 90 гаруй хувь нь аттестатчилалд хамрагдаж дийлэнх нь тухайн зэрэглэлийн болзолуудаа өндөр түвшинд биелүүлсэн.

#### **Анхаарах асуудал:**

- Оюутнуудын багшид өгсөн дундаж үнэлгээг нэмэгдүүлэхэд анхаарах

Үнэлгээ: Бүрэн хангасан

#### **Зөвлөмж:**

- Оюутнуудын зөвлөх үйлчилгээ авах эрэлт хэрэгцээг тодорхойлж, зөвлөх үйлчилгээг чанаржуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх

### **ШАЛГУУР 6.**

**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ:** Бүрэн хангасан

#### **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын бие даасан бүтэцтэй. (ХЧБХ-хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс)
- МУИС-ийн өнөөгийн сургалтын үйл ажиллагааг шинжлэн дүгнэх сургалтын чанарын тогтолцооны бүдүүвч (ӨҮТ, Зураг 7.1)
- МУИС-ийн хөтөлбөрийн хорооны журам
- Хөтөлбөрийн хороодуудын хурлын тэмдэглэл
- МУИС-ийн сургалтын хөтөлбөрийн журам
- Ажил олгогчидтой хийсэн уулзалт, ярилцлага

**Онцлог зүйл:**

- ХЧБХ-ээс (Чанарын албанаас) хөндлөнгийн үнэлгээг тогтмол хийж хэвшсэн.
- ХЧБХ-аас шаардлагатай судалгааг хийж тэнхимүүдэд хүргүүлдэг.
- МУИС-ийн хэмжээнд Хөтөлбөрийн ерөнхий хороо, Ерөнхий суурийн хөтөлбөрийн хороо, Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо, Салбар дундын хөтөлбөрийн хороо, Тэнхимийн хөтөлбөрийн хороодуудтай.
- ШУС-ийн захирлын А/345 тоот тушаалаар Эдийн засгийн тэнхимийн хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүн шинэчлэгдсэн. Тус бүрэлдэхүүнд ажил олгогч, төгсөгчийн төлөөлөл бий.

**Анхаарах асуудал:**

- Байхгүй.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:**

- Ажил олгогчдоос хөтөлбөрийн чанарын баталгаажилттай холбоотой судалгаа авдаг байх, эсвэл ажил олгогчоос авдаг сэтгэл ханамжийн судалгаанд энэ талаарх асуултуудыг нэмж оруулах, уг судалгааг тогтмолжуулах, хөтөлбөрийн шинэчлэлт сайжруулалт өөрчлөлттэй холбоотой мэдээллийг ажил олгогчдод тухай бүр хүргэдэг байх буюу мэдээллийн ил тод байдлыг хангах

**7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

**Илрэл нотолгоо:**

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа

- Төгсөгчдийн карьер хөгжлийн судалгаа /ӨҮТ-ийн хавсралт 7.4/
- Суралцагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ /ӨҮТ-ийн хүснэгт 7.4, хавсралт 7.1/
- Ажил олгогчоос авсан судалгааны үр дүн /ӨҮТ-ийн хавсралт 7.2/
- Төгсөгчдөөс авсан судалгааны үр дүн /ӨҮТ-ийн хавсралт 7.3/
- Ажил олгогчидтой хийсэн уулзалт, ярилцлага

#### **Онцлог зүйл:**

- Төгсөгчдийн ажил эрхлэлт жил бүр өсч байгаа. Сүүлийн жил төгсөгчдийн 76.5% нь 6 сарын дотор ажилд орсон.
- “Оюутан”, “Төгсөгч”, “Ажил олгогч” гэсэн 3 чиглэлээр 3 жил тутамд сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Суралцагч, төгсөгч, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн талаар мөшгөх үйл ажиллагаа хийгддэггүй.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Зөвлөмж:**

- Суралцагч, төгсөгч, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд үндэслэн хөтөлбөрийн үр дүнгийн сайжруулалт, хөгжүүлэлтийг хийдэг хэвшмэл үйл ажиллагааг бий болгох.

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Үндэсний магадлан итгэмжлэлийн гэрчилгээ (2011 он)
- Өөрийн үнэлгээний тайлан
- Ажил олгогч, төгсөгчидтэй хийсэн ярилцлага

#### **Онцлог зүйл:**

- МУИС нь 2018 онд 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн
- 1993 оноос тус хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн.
- ХЧБХ нь сургалтын бүх хөтөлбөрийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлэх зорилт тавин мастер төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа ба энэ ажлын хүрээнд тус хөтөлбөрийг үндэсний магадлан итгэмжлэл хийлгэх ажил процессын дагуу явагдаж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Үндэсний магадлан итгэмжлэлийн хугацаа 2016 онд дууссан байх бөгөөд энэ хооронд 6 жил завсардсан байгааг анхаарах.

**ҮНЭЛГЭЭ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:**

- Ахиц дэвшлийн болон ӨҮ-ний тайланг тогтсон хугацаанд бичиж магадлан итгэмжлүүлж байх. Олон улсад магадлан итгэмжлэл хийлгэхийг зорих, хэрэгжүүлэх.

**ШАЛГУУР 7.**

**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ:** Бүрэн хангасан

## ДУГНЭЛТ

МУИС-н Шинжлэх Ухааны сургуулийн “Эдийн засаг” (031101) бакалаврын хөтөлбөрт БМИҮЗ-ийн Захирлын №21/2023 тушаалаар ШУТИС-ийн БАТС-ийн захирал доктор, профессор Г.Баттүвшин, ХААИС-ын профессор доктор, профессор Д.Далхжав, СЭЗИС-н Суурь Шинжлэх ухааны тэнхимийн профессор, доктор Ч.Наранчимэг нарын баг 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдрөөс 2023 оны 6 сарын 5-ны өдрийг хүртэлх хугацаанд хөндлөнгийн шинжээчээр ажиллав.

МУИС-ийн Эдийн засаг хөтөлбөр нь 2014 оны Дээд боловсролын шинэчлэл болон МУИС-ийн бүтцийн өөрчлөлтийн нөлөөгөөр бүрэн шинэчлэгдэж өнөөг хүртэл тасралтгүй сайжирсаар байгаа билээ.

Хөтөлбөр нь агуулгын хувьд олон улсын тэргүүлэх их сургуулиудын шилдэг жишигт нийцсэн, хичээлүүдийн уядаа холбоо сайн хангагдсан, сүүлийн жилүүдэд улам чамбайрсан. Хөтөлбөрийн хэрэгжилт нь МУИС-ийн СиСи системээр дамжин хэрэгждэг учир хичээл сонголт, хичээлийн хуваарь, оюутны тоо, хичээлийн агуулга, багшийн цагийн гүйцэтгэл, суралцагчийн ирц, явцын болон эцсийн үнэлгээ зэрэг чухал асуудлыг сайтар хэрэгжүүлж, хянадаг. Сургалтын хөтөлбөр болон үйл ажиллагааг МУИС-ийн хэмжээнд нарийн зохицуулдаг. Эдгээр журмууд саяхан шинэчлэгдэж, улам сайжирсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд сайнаар нөлөөлнө гэж үзэж байна. Гэвч хөтөлбөрийн суралцахуйн үр дүн хичээлийн хөтөлбөрүүдэд бүрэн тусгагдаагүй, энэ ажил эхлэл төдий байгаа хэдий ч ахиц дэвшил ажиглагдаж байна<sup>2</sup>.

Өнөөдөр тухайн тэнхимд гадаад улс орнуудын тэргүүлэх их сургуулиудад эрдмийн зэрэг хамгаалсан олон залуу багш нар иажиллаж байна. Залуу багш нарын заах арга зүйн хувьд ахиц дэвшил гарч байгаа хэдий ч идэвхтэй суралцахуйн аргуудыг багш нар бүрэн эзэмшээгүй, туршлага дутмаг, хичээлийг гол төлөв уламжлалт хэлбэрээр явуулсаар байна. Мөн энэхүү үнэлгээг хийх явцад оюутныг чиглүүлэх, зөвлөх, туслах үйл ажиллагаа дутмаг, ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол хангаж чадахгүй байгаа, хөтөлбөрийн төлөвлөлт, шинэчлэлд бүхий л оролцогч талуудын оролцоог оновчтой хангаж чадахгүй байгаа зэрэг асуудал ажилагдаж байлаа. МУИС-ийн “Эдийн засаг” хөтөлбөр тасралтгүй сайжирч, олон улсын тэргүүлэх хөтөлбөрүүдийн жишигт

---

<sup>2</sup> Өөрийн үнэлгээний тайлангийн 175 дугаар тал



хүрсэн, суралцагч болон ажил олгогчийн шаардлагыг бүрэн хангасан хөтөлбөр болох нь ойлгомжтой.

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	(2)			
2	Сургалтын үйл ажиллагаа		(1)		
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	(2)			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	(2)			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	(2)			
6	Багшийн үйл ажиллагаа	(2)			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	(2)			
<b>Дүгнэлт</b>		<b>Бүрэн хангасан</b>			

### НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

/Нэгдсэн зөвлөмжид дээрх зөвлөмж, шаардлагыг шууд тусгахгүйгээр агуулгыг нэгтгэн сургуулийн удирдлага, хөтөлбөрийн баг бодитой хэрэгжүүлж, үр дүнд хүрэх боломжтойгоор томъёолж боловсруулсан байна./

Шалгуур		Зөвлөмж
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	
2	Сургалтын үйл ажиллагаа	
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн	
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	
6	Багшийн үйл ажиллагаа	
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	
<b>Шалгуур</b>		<b>Шаардлага</b>
...		

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн “Эдийн Засаг” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг ЭДИЙН ЗАСГИЙН чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг .....

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....

**V. Уулзалт ярилцлагад оролцогчдын бүртгэл**

**I. Багш нартай хийх уулзалт**

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл

**II. Оюутан, суралцагчидтай хийх уулзалт**

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Гарын үсэг

**III. Ажил олгогчидтой хийх уулзалт**

№	Овог нэрс	Ажлын газар	Албан тушаал	Утас	Гарын үсэг

**IV. Төгсөгсөгчидтэй хийх уулзалт**

№	Овог нэрс	Төгссөн он	Ажлын газар	Албан тушаал	Утас	Гарын үсэг

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**  
/албан бичгийг оруулах/

**ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) .....

Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт...

Зөвлөмж....

Шаардлага...

<b>Магадлан итгэмжлэх эсэх</b>	<b>Магадлан итгэмжлэл олгох хугацаа</b>

**ҮII. Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо).....

Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт...

Зөвлөмж....

Шаардлага...

<b>Магадлан итгэмжлэх эсэх</b>	<b>Магадлан итгэмжлэл олгох хугацаа</b>